



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 18 он 03
сарын 02 өдөр

Дугаар 3Г-1/
45

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Асуудал танилцуулах тухай

"Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 34 дүгээр тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүнгийн талаар Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд уг асуудлыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн байнгын хороодод тус тус танилцуулах нь зүйтэй гэж шийдвэрлэсний дагуу Танд үүгээр хүргүүлж байна.

Улсын Их Хурлын холбогдох байнгын хороодод дээрх асуудлыг танилцуулж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд

УХҮРЭЛСҮХ




000660

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны 8 дугаар тэмдэглэлд:

"ХҮ.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлын талаар Шадар сайд Θ.Энхтувшин Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

2. "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дунг цаашид авах арга хэмжээний саналын хамт Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн байнгын хороодод тус тус танилцуулахыг Шадар сайд бөгөөд Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах байнгын ажиллагаатай зөвлөлийн дарга Θ.Энхтувшинд даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх,
эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа,
тулгамдаж буй асуудлын талаар

Сүүлийн жилүүдэд монгол орны нутаг дэвсгэрт тохиолдож буй газар хөдлөлт тогтмол нэмэгдэж байна. Тухайлбал: 2008-2015 онд 16973-30111 удаа газар хөдлөлт тус тус бүртгэгдэж байсан бол 2016 онд 38442 удаа, 2017 онд 36437 удаагийн газар хөдлөлт болсон нь сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн идэвхижилт, эрсдэл манай улсад 1,3-2,1 дахин ёссенийг харуулж байна. 2017 онд 2,5-аас дээш магнитудын хүчтэй газар хөдлөлт 77 удаа тохиолдож, 21 газар хөдлөлт нь томоохон хот суурингийн оршин суугчдад мэдрэгдсэн нь энэ төрлийн байгалийн үзэгдэл манай төр засаг, ард иргэдийн өмнө гамшигийн аюул занал болон тулгарах томоохон эрсдлийг бий болгож байна.

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл нь Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө" болон Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр гаргаж танилцуулгад хавсаргав.

Гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээ авах журам, "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-тэй болох тухай Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолыг тус тус батлуулав. Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг хүчитгэх, буулгаж шинээр барих болон холбогдорх хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 20 гаруй дүрэм, журам, бусад эрх зүйн баримт бичгийг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Байнгын ажиллагаатай зөвлөлөөс 2017 онд аймгуудад Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийг байгуулснаар үйл ажиллагаагаа нийт улс орныг хамруулан зохион байгуулах боломжтой боллоо. Аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг шалган зааварлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгөх ажлын хэсгийг бүх аймгуудад байгуулаад байна. Ажлын хэсгээс аймгийн салбар зөвлөлд жил бүрийн төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж батлуулан хэрэгжүүлэх, дараа жилийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг улс, орон нутгийн төсөвт тусгуулж байх, олон нийтийн зориулалтын барилгын судалгааг бүрэн гаргах, барилгуудыг паспортжуулах, орон сууцны барилгуудыг СӨХ-той болгох, хотын хөгжлийн еренхий төлөвлөгөөнд ашиглалтын шаардлага хангахгүй барилгын дахин төлөвлөлтийг тусгах, Барилгын хийц, материалын чанарыг шалгах лабораторийг шаардлагатай тоног төхөөрөмж, боловсон хүчинээр хангаж бэхжүүлэх, гамшигийн үед иргэд цугларах талбай, хоргodoх байрыг томилгоожуулах, стандарт тогтоож, тохижуулах, Гамшигийн аюулыг зарлан мэдээлэх, шуурхай удирдлага зохицуулалтаар хангах төв байгуулах, Гамшгаас хамгаалах олон нийтийн сургалт,

дадлагын танхимтай болох чиглэлийг өгч, эдгээр ажлын хэрэгжилтийг зохион байгуулж байна.

2017 онд аймаг, орон нутагт хийсэн нэгдсэн судалгаагаар сургуулийн 823 барилгаас 165 нь, цэцэрлэгийн 667 барилгаас 94, эмнэлэгийн 652 барилгаас 78, соёл урлагийн байгууллагын 406 барилгаас 107 нь буюу нийт барилгын 10,5 хувь нь ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй болох нь холбогдох байгууллагуудын хийсэн нэгдсэн үзлэг шалгалтаар тодорхойлогдсон.

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт 6627 орон сууц ашиглагдаж байна. Үүнээс 3895 барилга байгууламж нь буюу 59 хувь нь нийслэл хотод, 2732 барилга байгууламж нь буюу 41 хувь нь аймаг, орон нутагт байна. Ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон нийтийн орон сууцны зориулалттай барилга нийслэлд 349, орон нутагт 702, үүнээс мэргэжлийн хяналтын байгууллагаас ашиглахыг хориглосон нийслэлд 234, орон нутагт 221 барилга байна. Нийслэлээс ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг дахин төлөвлөлтөд оруулахаар 131 барилгыг 45 багц болгон хэсэгчилсэн төлөвлөгөөг хийж, шалгаруулалтын ажиллагаа явуулснаас 19 хэсэгт 60 барилгыг буулгаж шинээр барих теслүүд хэрэгжиж байна. Энэ ажлын хүрээнд 2016-2017 онд 301 айлын 3 орон сууц ашиглалтад орсон ба 12 барилгыг буулган, барилга угсралтын ажил хийгдэж байна. 26 багцын 71 барилгад хөрөнгө оруулах тесэл хэрэгжүүлэгчийг урьж, сонгон шалгаруулалтыг удаа дараа зарлаж байгаа боловч эдийн засгийн хямрал болон бусад шалтгааны улмаас гүйцэтгэгчийн санал гарахгүй байна.

Аймгийн төв, томоохон хот сууринд дээрхтэй адил нехцэл байдал үүссэн 221 орон сууцны барилга байгаа бөгөөд Баянхонгор аймгийн төвийн 12 айлын орон сууцны барилгын зарим хэсэг нурсныг аймгийн Засаг даргын Тамгын газар, оршин суугчид, барилгын "Харгана Асгат" компанитай 3 талын гэрээ байгуулж, орон нутгийн төсвөөс айл бүрт 20,0 сая төгрөг гарган, дахин төлөвлөлтийн теслийн хүрээнд 30 айлын орон сууц барьж, 12 айлын орон сууцны нехцлийг шинэчлэн сайжруулсан нэг л тесэл амжилттай хэрэгжсэн. Гэвч орон нутагт орон сууцны үнэ Улаанбаатарынхаас хэт доогуур учир Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Орон сууцны тухай хуулийн дагуу ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны оронд шинээр барилга барих хөрөнгө оруулагч, хөрөнгийн эх үүсвэр олддоггүй бэрхшээл нийтлэг болоод байна. Эдгээр ашиглалтын шаардлага хангахгүй олон нийтийн зориулалтын барилгыг буулгаж шинэчилж барих ажлыг богино хугацаанд зохион байгуулах нь төрөөс ард иргэдийнхээ аюулгүй орчинд амьдрах, ажиллах нехцлийг бүрдүүлэх ойрын чухал зорилт болох юм. Энэхүү ажлын хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Улсын Их хурлын холбогдох байнгын хороодод танилцуулж, ялангуяа санхүүжилтийг шийдвэрлэх талаар тодорхой чиглэл гаргуулан, түүний дагуу "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууц, сургууль, цэцэрлэг, соёл, урлагийн байгууллага, эмнэлэг зэрэг олон нийтийн буулган шинээр барих арга хэмжээний төлөвлөгөө"-г боловсруулж, Засгийн газраар батлуулахаар төлөвлөж байна.

Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй олон нийтийн зориулалтын барилгыг 2018-2024 онд буулгаж шинээр барих дахин төлөвлөлтийн теслүүдийг танилцуулгад хавсаргав.

Мөн зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд томоохон хот суурингуудын газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын ажлыг ирэх 2 жилийн хугацаанд

бурэн хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Судалгааны дунгээс харахад зөвхөн Улаанбаатар хот төдийгүй бусад томоохон хот суурин газруудын газар хөдлөлтийн идэвхижилт эрс нэмэгдэж байгаагийн улмаас урьд зохиогдсон бичил мужлалын зургийн нөхцөл шаардлагууд 1 баллаар өсч гарах тооцоолол гарч байна. Үүний үр дүнд шинээр баригдах барилгууд техникийн шаардлагын хувьд газар хөдлөлтөд тэсвэртэй баригдахын тулд илүү бат бөх тооцооллоор зураг тесэл хийгдэх шаардлага тулгарах юм. Барилгын чанар, аюулгүй байдлыг хянах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх үүднээс бүх аймгуудад лабораториудыг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн төвлөрлийг сааруулж задлах, иргэд, оршин суугчдын ажиллаж, амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх үүднээс дагуул хотуудыг байгуулах судалгаа, төлөвлөлтийн ажлууд эрчимтэй явагдаж байна. Үүнтэй холбоотой Төрийн ордонд байрладаг төрийн дээд байгууллагуудыг аюулгүй байрлалд шилжүүлэн төлөвлөх саналыг боловсруулаад байна.

Онцгой байдлын ерөнхий газрын харьяанд "Эрэлч нохойн алба"-ыг байгуулж, 21 аймаг, нийслэлийн иргэдийг гамшигийн үед нүүлгэн шилжүүлэх байршил, түр цугларах талбайг томилгоожуулж, олон улсын байгууллагын дэмжлэгээр 157.6 сая төгрөгийн үнэ бүхий эрэн хайх, аврах тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг авч холбогдох байгууллагуудад хуваариллаа.

Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтолцоо батлагдсан "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийг тэмдэглэх хүрээнд газар хөдлөлтийн гамшигийн аюулыг иргэдэд таниулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төле хичээл, сургалтын материал бэлтгэн, олон нийтийн телевизээр гаргаж, 21 аймаг, нийслэлийн хэмжээнд газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр өдөрлөг зохион байгуулав. Өмнөговь аймагт "Говийн чоно-2017" олон улсын хамтарсан дадлага, сургууль, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Хөвсгөл аймагт "Гамшигаас хамгаалах иж бүрэн сургууль". Архангай аймагт гамшигаас хамгаалах команд штабын сургууль, Дорнод аймагт зүүн бүс, Ховд аймагт баруун бүсийн Онцгой байдлын газруудын команд штабын сургууль, "Гамшигаас аюулаас хамгаалах боломж" сэдэвт эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уралдааныг тус тус зохион байгуулан ажиллалаа.

Хэдийгээр эдийн засгийн болон бусад бодитой хүндрэл бэрхшээл тулгарч байгаа ч Улсын Их хурал, Засгийн газраас газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад онцгой анхаарч, дэмжлэг үзүүлж байгаа учир Байнгын ажиллагаатай зөвлөлөөс төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад үйл ажиллагаа, ялангуяа ашиглалтын шаардлага хангахгүй олон нийтийн зориулалтын барилгын дахин төлөвлөлтөд шаардлагатай зардлыг цаашид үе шаттайгаар жил бүрийн улсын төсөвт тухай бүр суулгах, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл өмнөө тавьсан зорилтоо биелүүлэх боломжтой гэж үзэж байна.

Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлөөс үйл ажиллагаанд тулгарч буй асуудлаар хийсэн танилцуулгатай Улсын Их Хурлын гишүүд танилцаад тодорхой чиглэл гаргавал хэрэгжүүлж ажиллах болно.

**ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
БАИНГЫН АЖИЛЛАГААТАЙ ЗӨВЛӨЛ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ "ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ
БУРУУЛАХ ТАЛДААР АВАХ ЗАРИМ АРТА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 34 ДҮГЭР ТӨГТООЛЫН БИЕЛЭЛТ**

2018 оны 01 дугээр сарын 24-ний өдөр

№	Ажил	Биелэлт	Хувь
1	Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилсан сэргийлэх, эрсдэлийг бууруулах салбар хоорондын үйл ажиллагааг хангах чиглэлээр хууль хамтын ажиллагааг хангах чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Гамшигаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн нариуулга, Барилгын тухай хуулийг шинэчлэн батлуулж, хуулийг дагалдан гарах дүрэм, журмуудыг боловсруулан батлуулж байна.	100
2	Монгол орны болон Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхжилт, цаащдын төлөө байдал, аюулын үнэлгээний судалгаа болон мониторингийн ажлыг өргөжүүлж, томоохон хот, суурин газрын газар хөдлөлтийн бичил мужлалын зурагийг шинэчлэх, хийж гүйцэтгэх;	Улаанбаатар хот, алслагдсан дуургийн хөрсний судалгааг хийж, газар хөдлөлтийн бичил мужлалын зурагийг шинэчлэн батлуулсан. 12 (Төв, Хэнтий, Дундговь, Дорнговь, Говьсумбэр, Орхон, Баян-Өлгий, Архангай, Овхорхангай, Сүхбаатар, Дархан-Уул, Дорнод, Баянхонгор) аймгийн төвийн хөрсний судалгааг хийж, газар хөдлөлтийн бичил мужлалын зурагийг шинэчлэн гаргасан. 9 аймгийн төвийн хөрсний судалгааг хийж, газар хөдлөлтийн бичил мужлалын зурагийг шинэчлэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн бөгөөд уг ажлыг 2018-2019 онд хийж гүйцэтгэнэ.	70
3	Засгийн газрын 2018.02.22-ны хураалдаанаар "Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах ажлын хурээнд хотын баруун ёмнид бусад нийслэлийн төр захирагааны байгууллагуудыг шилжүүлэн байршуулах тухай" асуудлыг ЗГХЭГ-ын дарга танилцуулж, НИПХ, Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, түүний харьяа байгууллагуудыг Хан-Уул дуургийн 4, 8 дугаар хорооны нутаг дэвсгэр /Яармаг шинэ төв/-т шилжүүлэн байршуулах бэлтгэлээ шурхай хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгасан. Нийслэлийн төр, захирагааны байгууллагуудад 1933 хүн ажилладаг бөгөөд өдөрт дунджаар 5700 иргэн, аж ахуйн нэгжид 332 нэр төрлийн үйлчилгээ үзүүлдэг байна. Яармагт шилжүүлснээр чийгчилгээ авах гэсэн дээрх хэдэн мянган хүн хотын төвийг зорих шаардлагатай болох юм. Цаашид Засгийн газар,	Хуваанбаатар хотын төвлөрлийг сааруулах ажлын хурээнд хотын баруун ёмнид бусад нийслэлийн төр захирагааны байгууллагуудыг шилжүүлэн байршуулах тухай" асуудлыг ЗГХЭГ-ын дарга танилцуулж, НИПХ, Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, түүний харьяа байгууллагуудыг Хан-Уул дуургийн 4, 8 дугаар хорооны нутаг дэвсгэр /Яармаг шинэ төв/-т шилжүүлэн байршуулах бэлтгэлээ шурхай хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгасан. Нийслэлийн төр, захирагааны байгууллагуудад 1933 хүн ажилладаг бөгөөд өдөрт дунджаар 5700 иргэн, аж ахуйн нэгжид 332 нэр төрлийн үйлчилгээ үзүүлдэг байна. Яармагт шилжүүлснээр чийгчилгээ авах гэсэн дээрх хэдэн мянган хүн хотын төвийг зорих шаардлагатай болох юм. Цаашид Засгийн газар,	30

		яамдыг дагуул хот руу шилжүүлэн байрлуулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлэхээр судалж байна.	
4	Төрийн ордонд байрладаг байгууллагуудыг шилжүүлэн байрлуулах саналыг боловсруулж 2016 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;	Ажлын хэсгээс боловсруулсан "Төрийн ордны барилгын чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Төрийн ордны барилгын чанарыг ШУТИС-Н харьяа "Реконстракшин" төвөөр судлагаа, тооцоо хийлгэж, тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргуулсан. Төрийн ордонд байрладаг байгууллагуудыг тур нүүлгэн шилжүүлэн байршуулах байруудын засварын төсөвт өртгийг тооцон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна.	70
5	Орон сууч, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтэд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтэд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглаж боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдээрийг че шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах;	2017 онд аймаг, орон нутагт хийсэн нэгдсэн судалгаагаар сургуулийн 823 барилгаас 165 нь, цэцэрлэгийн 667 барилгаас 94, эмнэлэгийн 652 барилгаас 78, соёл урлагийн байгууллагын 406 барилгаас 107 нь буоу нийт барилгын 10,5 хувь нь ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтэд тэсвэргүй болж нь холбогдох байгууллагуудын хийсэн нэгдсэн үзлэг шалгалаар тодорхойлогдсон. Улсын хэмжээнд 2018 оны байдааар нийт 6627 орон сууч ашиглагдаж байгаагаа 3895 барилга байгууламж нь нийслэл хотод, 2732 барилга байгууламж нь аймаг, орон нутагт байна. Ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтэд тэсвэргүй нь тогтоогдсон нийтийн орон суучны зориулалттай барилга нийслэлд 349, орон нутагт 702, чуннаас мөргөжлийн хяналтын байгууллагаас ашиглахыг хориглосон нийслэлд 234, орон нутагт 221 барилга байна. Нийслэлд 60 барилгыг шинэчлэх төсөл хэрэгжиж байна.	70
		Улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай ашиглалтын шаардлага хангахгүй орон сууч, сургууль, цэцэрлэг, соёл, урлагийн байгууллага, эмнэлэг зэрэг олон нийтийн зориулалтын барилгын дахин төлөвлөгөөний таслийг боловсруулаад байна. Төлөвлөгөөний төсвэлд 2018-2020 онд ашиглалтын шаардлага хангахгүй 339 барилгыг шинэчилж барихад 760,1 тэрбум төгрөг, 2020-2024 онд 379 барилгад 966,8 тэрбум төгрөгийн санхүүжилт шаарддагдах тооцоо гарсан. Уг асуудлыг УИХ-ын байнгын хороонд танилцуулж чиглэл авснаар "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууч, сургууль, цэцэрлэг, соёл, урлагийн байгууллага, эмнэлэг зэрэг олон нийтийн буулган шинээр барих арга хэмжээний төлөвлөгөө"-г	2

		Боловсруулж, Засгийн газраар батлуулахаар төлөвлөж байна.
6	Барилга байгууламжийн хийц, бүтээч, эдлэхүүн, материал, түүхий чанар, аюулгүй байдлын узүүлэлтийг тодорхойлох, техник технологийг туршин шалгаж, дүгнэлт гаргах чиг Урэг бүхий нэгдсэн лабораторийг барилгын асуудал төв байгуултын харьяанд ажилтуулж, орон шийдвэрлэгдээгүй тул 2019 оны төсөөт суулгахаар ажиллаж байна.	Барилга байгууламжийн хийц, бүтээч, эдлэхүүн, материал, түүхий эдийн бат бэх чанар, аюулгүй байдлын узүүлэлтийг тодорхойлох, техник технологийг туршин шалгаж, дүгнэлт гаргах чиг Урэг бүхий нэгдсэн лабораторийг барилгын асуудал төв байгуултын харьяанд ажилтуулж, орон шийдвэрлэгдээгүй тул 2019 оны төсөөт суулгахаар ажиллаж байна. 30
7	Газар хөдлөлтийн гамшигаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшигийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэөчийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилсан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	"Онцгой нөхцөл байдал чуссан үед Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, онцгой байдал, тагнуул, шүүхийн шийдвэр, цагдаагийн байгууллагын харилцан ажиллах төлөвлөгөө" болон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 656 цэцрэлэг, 686 сургууль, 512 эмнэлгийн байгууллагын гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийсэн. Төв, орон нутгийн гамшигаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох ажлын хурээнд 21 аймаг, нийслэлийн иргэдийг гамшигийн үед нүүлгэн шилжүүлэх байршил, тур цугларах талбайг томилгоожуулан тэмдэгжүүлсэн. Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтолцоор батлагдсан "Газар хөдлөлтийн аюулас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийг тэмдэглэх хүрээнд газар хөдлөлтийн гамшигийн аюулыг иргээд таниулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөх чихээл, сургалтын материал балтгэн олон нийтийн төлөвийзэр гаргаж, 21 аймаг, нийслэлийн хэмжээнд газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр өдөрleg зохион байгуулсан. Өмнөгөвь аймагт "Говийн чоно 2017" олон улсын хамтарсан дадлага, сургууль, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Хөвсгөл аймагт "Гамшигаас хамгаалах их бүрэн сургууль", Архангай, гамшигаас хамгаалах команд штабын сургууль, Дорнод аймагт зүүн бус, Ховд аймагт баруун бүсийн Онцгой байдлын газруудын команд штабын сургууль, "Гамшигаас аюулаас хамгаалах боломж" сэдэвт эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уралдааныг тус тус зохион байгуулсан. Онцгой байдлын албыг бүсийн удирдлагын төв байгуулж, шурхай удирдлага, зарлан бусад шурхай удирдлагын төв байгуулж, шурхай удирдлага, зарлан

		МЭДЭЭЛЭХ ТӨВТЭЙ ХОЛБОСОН. Гамшигийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтөх тооцоо судалгааг хийж, төсөл боловсруулан 2019 оны улсын төсөвт тусгуулах, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна.	
8	"Газар хөдлөлтийн гамшигаас үрьдчилан сэргийлэх, эрсдэлтийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бурийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байж.	Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоопоор "Газар хөдлөлтийн гамшигаас үрьдчилан сэргийлэх, эрсдэлтийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г батгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дундаж	100 70

**ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМИШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
БАЙНГЫН АЖИЛЛАГАТАЙ ЗӨВЛӨЛ**

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг
бууруулах үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлын талаар
танилцуулах ажлын хэсэг

1. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн дарга Θ.Энхтувшин
2. Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан
3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд Е.Отгонбаяр
4. Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн
5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд
6. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн
7. Онцгой байдлын ерөнхий газрын дарга Т.Бадрал
8. Мэргэжлийн хяналтын газрын дарга Н.Цагаанхүү
9. Нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүү
10. Шадар сайдын Ажлын албаны дарга, Ахлах зөвлөх Л.Саянаа
11. УАБЗ-ийн Ажлын албаны референт Е.Жаргалсайхан
12. БХБЯ-ны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Соёмбоо
13. Улаанбаатар хотын ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга Э.Анар
14. МХЕГ-ын Дэд бүтцийн хяналтын газрын дарга Д.Жаргал
15. ШУА-ын Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэл
16. ОБЕГ-ын тасгийн дарга З.Баттулга
17. БХБЯ-ны ББМУБХЗГ-ын мэргэжилтэн О.Баярбаатар

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ЗӨВЛӨЛ